



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/272

Номгон

Шинэжинст сумын 240 хүний суудалтай
соёлын төвийн барилгын нэмэлт ажлын
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 тэмдэглэлд заасны дагуу Шинэжинст сумын 240 хүний суудалтай соёлын төвийн барилгад гадна дулаан, цэвэр, бохир ус, холбооны ажлууд зураг төсөвт тусгагдаагүй тул нэмэлтээр 191,600,000 /нэг зуун ерэн нэгэн сая зургаан зуун мянган/ төгрөгийн нэмэлт ажил дээр "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1 дэх заалтыг үндэслэн гүйцэтгэгч компани болох "Стандарт тоосго" ХХК-тай гэрээ байгуулсугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т зөвшөөрсүгэй.

3. Нэмэлт ажилд, хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т даалгасугай.

4. Төсвийн тухай хуулийн 46.3.1 дэх заалтын дагуу нэмэлт ажлын төсвийг санхүүжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т хариуцуулсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220833



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/281

Номгон

“Дижитал Баянхонгор” арга хэмжээний хүрээнд
“Инспайер 2022” төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2 дугаар заалт, аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 7.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоол, 2019 оны 149 дүгээр тогтоол, 2020 оны 90 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем”-ийг иргэдэд сурталчлан таниулах, орон нутгийн иргэдэд мэдээлэл технологийн ур чадвар олгох сургалт нөлөөллийн төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн ур чадварыг нэмэгдүүлэх “Инспайер 2022” арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг хамтын ажиллагааны гэрээний дагуу өндөр түвшинд зохион байгуулахыг “Эмпасофт” ХХК-д, зохион байгуулалтыг хамтран хэрэгжүүлж, төрийн албан хаагч болон иргэдийг идэвхтэй оролцуулахыг “Дижитал Баянхонгор” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 19,999,100 (Арван есөн сая есөн зуун ерэн есөн мянга нэг зуун) төгрөгийг аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220705



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/282

Номгон

“Дижитал Баянхонгор” арга хэмжээ зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 Төсвийн тухай хуулийн 14.2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.2 дүгээр заалт, аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний 7.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 2018 оны 259 дүгээр тогтоол, 2019 оны 149 дүгээр тогтоол, 2020 оны 90 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем”-ийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлт, төрийн албан хаагч болон төрийн үйлчилгээний оператор ажилтныг сургах “Дижитал Баянхонгор” арга хэмжээг зохион байгуулсугай.

2.“Дижитал Баянхонгор” арга хэмжээг удирдлага зохион байгуулалтын өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 20,000,000 (Хорин сая) төгрөгийг аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220707



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/284

Номгон

«Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/23 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний “Халамжаас-Хөдөлмөрт” бүлгийн 2.5.9 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийн зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2.Үйл ажиллагаанд шаардагдах 2 000 000 (Хоёр сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Байгаль орчин, уул уурхай, нийгмийн салбар хариуцсан орлогч (Ж.Мөнхсоёл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220711

Аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын
25-ны өдрийн 11/284 дугаар захирамжийн
хавсралт



**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ
АХУЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ АЖЛЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САНХҮҮЖИЛТИЙН
ЗАРДЛЫН ТООЦОО**

1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяны үйл ажиллагааны зардлын төсөв


№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт /төгрөг/
1	2	3	4	5	6
1	Стекер, самбар	Ширхэг	5	30000	150 000
2	Шторк	Ширхэг	2	200000	400 000
3	Цагаан цахир орох болон барилгуудаар явах шатахуун	литр	50	2600	130 000
4	Өргөмжлөл	Ширхэг	10	30000	300 000
Дүн					980 000

2. ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ САЛБАРТ ХАБЭА-Н ҮЗЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Гарах зардал	Нийт төгрөг
1	2	3
1	Шатахууны зардал	1 020 000
Дүн		1 020 000
Нийт зардал		2 000 000

_____ооо_____

ДАРГА
Д.МӨНХСАЙХАН



(Ж.Мөнхсөөл)-д даалгасунай

Засаг даргын Байгаль орчин уул уурхай, нийгмийн салбар харуцсан орлогч
3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, танилцуулж ажиглахыг аймгийн
зөвшөөрсүгэй.

санхүүжүүлж ажиглахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалаа)-д
аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас
2.Дээрх үйл ажиллагаанд шаардгдах 8,000,000 (найман сая) төгрөгийг

хэмжээ авч ажиглахыг Татварын хэлтэс (С.Рэнцэндава)-т үүрэг болгосугай.
цахираар татвар төлөх хандлагыг төлөвшүүлэх татварын бүртгэл мэдээллийг
сэргээж татварын бааз суурь, орлогын гүйцэтгэлийг нэмэгдүүлэхэд арга
1.Шинэчлэгдэн батлагдсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүнийн
удирдлагын тухай хуулиар дараа батлагдсан Төсвийн тухай хуулийн
өөрчлөлт болон татварын хууль эрхзүйн актуудын шинэчлэлийг хэрэгжүүлэх,

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын
тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.10 дахь заалт, Төсвийн тухай
хуулийн 14 дүгээр зүйл 14.2.3 дахь заалт, аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө
3 дугаар зүйл 3.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Татварын хууль эрхзүйн актуудын шинэчлэлийг
хэрэгжүүлэх, орлогын бааз суурийг нэмэгдүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Номтон

Дугаар А/301

Онцгой дарга 07 сарын 28 өдөр

МОНГОЛ УЛС
БАНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ





МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/315

Номгон

Аймгийн тогоочдын ажил мэргэжлийн
уралдаан зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/23 дугаар тогтоол “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө”-ний 3.2.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад ажиллаж буй мэргэжлийн тогооч нарын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, орон нутгийн онцлогтой бренд хоол, ундааг шалгаруулах, харилцан туршлага солилцох зорилгоор ажил мэргэжлийн уралдааныг 2022 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Ажил, мэргэжлийн уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, уралдааны удирдамж, хөтөлбөрийг хоёрдугаар, ажлын даалгаварыг гуравдугаар, үйл ажиллагааны зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3.Уралдааны нийт зардалд 3,500,000 төгрөг зарцуулж, 2,000,000 (хоёр сая) төгрөгийг холбогдох байгууллагууд санхүүжүүлж, үлдэгдэл 1,500,000 (нэг сая таван зуун мянган) төгрөгийг 2022 оны хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220781

Аймгийн Засаг даргын *М.Д.* оны *15* дугаар сарын *02*-ны өдрийн *1/31* дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН 2022 ОНЫ АЙМГИЙН
АВАРГА ТОГООЧ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ
УДИРДАМЖ**

Зорилго: Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудад ажиллаж буй мэргэжлийн тогооч нарын ур чадвар, чадамжийг дээшлүүлэх, орон нутгийн онцлогтой бренд хоол, ундааг шалгаруулах, харилцан туршлага солилцоход оршино

Зорилт: Улс, бүсийн уралдаанд оролцох тогооч нарыг шалгаруулах, бэлтгэл хангах,

Хамрах хүрээ: Баянхонгор аймгийн хэмжээнд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ресторан, баар, кафе, цайны газар, эмнэлэг, цэцэрлэг, сургуульд ажиллаж буй тогооч нар, Политехник коллежид мэргэжлээрээ суралцаж байгаа оюутнууд оролцоно.

Ерөнхий зохион байгуулагч:

Баянхонгор аймгийн ЗДТГ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс

Баянхонгор аймгийн Политехникийн коллеж

Хамтран зохион байгуулагч:

- Баянхонгор аймгийн Хоол үйлдвэрлэгчдийн холбоо
- Баянхонгор аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газар
- Байгаль орчин аялал жуулчлалын газар
- Худалдаа аж үйлдвэрийн танхим
- Эрүүл мэндийн газар
- Боловсрол, шинжлэх ухааны газар

Уралдааныг зохион байгуулах газар, хугацаа:

2022 оны 05 дугаар сарын 12-13-ны өдрүүдэд Баянхонгор сумд зохион байгуулна. /Зохион байгуулагдах газрыг техникийн зөвлөгөөн дээр зарлана/

Уралдааны төрөл:

Уралдааныг: Хоолны газрын төрөл ангилал, зэрэглэлийн дагуу тогооч нарыг төрөлжүүлэн бүртгэж оролцуулна. Үүнд: /Бүртгэлийн хураамж, хүнсний материалын үнэ/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

№	Үйл ажиллагаа	Цаг	Хариуцах байгууллага
2022 оны 05 дугаар сарын 11			
1	Техникийн зөвлөгөөн	14:00:15:00	Политехникийн коллеж Мэргэжлийн хяналтын газар
2	Бүртгэл	15:00-17:00	Зохион байгуулах ажлын хэсэг
2022 оны 05 дугаар сарын 12			
1	Нээлт	09:00:09:15	АЗДТГ, ХХААГ, Политехникийн коллеж
2	Брэнд хоол шалгаруулах	09:15-10:15	Зохион байгуулах ажлын хэсэг
3	Ресторан, зоогийн газар, кафе-н төрлийн уралдаан	11:00-13:00	
4	Гуанз, цайны газрын төрлийн уралдаан	15:00-17:00	
2022 оны 05 дугаар сарын 13			
1	“Эмнэлэг, сувилалын хоол” төрлийн уралдаан	09:00-11:00	Зохион байгуулах ажлын хэсэг
2	“Сургууль, цэцэрлэгийн үдийн хоол” төрлийн уралдаан	12:00-14:00	
3	Талх нарийн боов” төрлийн уралдаан	15:00-17:00	
4	Хаалт, шагнал гардуулах	17:00-18:00	

Техникийн зөвлөгөөн 2022 оны 05 сарын 11-ний өдрийн 14:00 цагт болно /

заавал хамрагдана.

Уралдаан болохоос 2 хоногийн өмнө бүртгүүлж, техникийн зөвлөгөөнд

оролцох эрхтэй.

Тогооч нар өөрсдийн хүсэл сонирхлын дагуу уралдааныг 3 хүртэлх төрөлд

Уралдаанд оролцохч тогооч нарын хүлээх үүрэг:

- Шүүмэдийн үнэлгээг нийтэд харгалдахуйц байдлаар байрлуулах / Дэлгэцээр/
- Оролцоогчдод хоол хүнс бэлтгэхээс бусад түслалцааг үзүүлэх
- Оролцоогчдод шаардлагатай тохиолдолд эмнэлэгийн анхны түслэмж үзүүлэх
- Усаар хангах
- нойтон хот хаягдлын сав, сальфетка гэх мэт/
- Хөдөлмөрийн аюулгүй байдлыг, Эрүүл ахуйн шаардлагыг хангах /Хуурай,
- Ажлын байр, бэлтгэлийн ширээ, хоол олгох ширээ зэрэг хангах
- Мэргэжлийн уралдаан тэмцээнд оролцоогчдыг бүртгэн мандат олгох

Зохион байгуулагч талаас хүлээх үүрэг:

Тогооч нар хоол тус бүрийг 2 порцоор хийх ба тавалгалт ижил байна.

ашиглалт зэргийг шүүмэждээс онцгойлон дүгнэнэ.

орулж хийх. Материалыг хэрхэн ашигласан байдал, багаар ажиглах чадвар, цаг

Орчин үеийн дэвшилтэт шинэлэг шиж чанартай байх, нарийн ажигбар

урамшуулна

гаргасан Хоолны газар, аж ахуйн нэгж, Мэргэжлийн тогоочийг шалгаруулж,

Мөн Орон нутгийн онцлолт тохирсон брэнд хоол, ундааны үзэсгэлэн

шийдвэрийг харна.

Жич: Оролцоогчийн тоо хүрэхгүй тохиолдолд зохион байгуулагч нарын

- Политехник коллежийн оюутнууд – 30000
- Нарийн боовчин-35000 /Оролцоогчийн тоо 8-аас дээш/
- Сургууль, үдийн цайны тогооч- 50000 /Оролцоогчийн тоо 10-аас дээш/ дээш/
- Эмнэлэг, сувилалын хоолны тогооч-50000 /Оролцоогчийн тоо 10-аас
- Гуанз, цайны газрын тогооч-50000 /Оролцоогчийн тоо 10-аас дээш/ аас дээш/
- Ресторан, зоогийн газар, кафе-н тогооч- 60000 /Оролцоогчийн тоо 10-
- Орон нутгийн брэнд хоол шалгаруулах /Үзэсгэлэн гаргах/ Төлбөргүй

шалгаруулан өргөмжилж шанаана.

Үзэсгэлэнд гаргасан Орон нутгийн онцлогт тохирсон бренд хоол, ундааг

5. Талх, нарийн боовчин-өргөмжлөл, мөнгөн шагнал
4. Сургууль, цэцэрлэг үдийн хоол тогооч-өргөмжлөл, мөнгөн шагнал
3. Эмнэлэг, сувиллын хоолны тогооч-өргөмжлөл, мөнгөн шагнал
2. Гуанз, цайны газрын тогооч-өргөмжлөл, мөнгөн шагнал
1. Ресторан, зоогийн газар, кафе-н тогооч өргөмжлөл, мөнгөн шагнал

олгоно.

Уралдааны төрөл тус бүрээр 1-3-р байр эзлүүлж, өргөмжлөл, мөнгөн шагнал

Уралдааны шагнал урамшуулал:


- Оролцогчид ямар нэгэн хүнсний бүтээгдэхүүн авч ирэхгүй байх
- Хөтөлгөчийн "Эхлэх" командаар ажигбарыг эхлэх
- ХАБЭА-н шаардлагыг бүрэн ханган ажиглах
- таваг, ажлын мод зэргийг бэлтгэсэн байх
- Ажигбарт шаардлагад багаж хэрэгсэл, газрын плитка, сав суулга,
- Ажлын хувцасыг бүрэн, зөв өмссөн байх
- Заасан хугацаанд багтаж ажлын байраа бэлтгэсэн байх

Оролцогч дараах зарчмаар Уралдаанд оролцоно. Үүнд:

Үүнд: Тогоочийн анкет, 3*4 хэмжээтэй цээж зураг -1%

Оролцогчид бүртгүүлэхээр ирэхдээ: дараах материалыг бүрдүүлнэ.

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 1215 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЙМГИЙН АВАРГА ТОГООЧ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Ч.Цэрэнпагма – Баянхонгор аймгийн Хоол
үйлдвэрлэгчдийн холбооны тэргүүн, Баянхонгор
Политехникийн коллежийн багш

Гишүүд: Б.Биндэръяа Аймгийн Засаг даргын Тамгын газар,
Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын
хэлтсийн мэргэжилтэн

Д.Мөнх-Эрдэнэ Эрүүл мэндийн газар, Хоол тэжээл,
хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн

С.Сайнхүү Хүнс, хөдөө аж ахуйн газар, Хүнс, нийтийн
хоол, худалдаа хариуцсан мэргэжилтэн

Д.Содномсамдан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын аялал
жуулчлалын ахлах мэргэжилтэн

Д.Энхтүвшин Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн
танхимын дарга

Н.Хулан Баянхонгор сумын Засаг даргын тамгын газар,
Хүнс, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан
Мэргэжилтэн

Ч.Жавзандулам Мэргэжлийн хяналтын газар, Хүнсний чанар стандартын
хяналтын улсын байцаагч

Б.Дэнсмаа Баянхонгор Политехникийн коллежийн багш

Н.Алтансүх Баянхонгор Политехникийн коллежийн багш
Монголын тогооч нарын холбоо, Мастер тогоочдын
холбоо /зөвшилцснөөр 2 гишүүн/

_____оОо_____

Аймгийн Засаг даргын _____ оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 11.25 дугаар захирамжийн 3 дугаар хавсралт



УРАЛДААНД ОРОЛЦОХ АЖИЛБАРЫН ДААЛГАВАР

1. Ресторан зоогийн газар, кафе-н төрөл- Өгөгдсөн материалаар үндсэн хоолыг 2 порцоор хийнэ. Орчин үеийн дэвшилтэт шинэлэг шинж чанартай, сүмс болон бүтээгдэхүүний зохицол тохирсон байна. Анхны боловсруулалт, дулааны боловсруулалт, таваглалт зэргийг 45 минутанд багтааж гүйцэтгэнэ. **/Технологийн карт заавал хийгдсэн байна./**

2. Гуанз, цайны газрын тогооч – Өгөгдсөн хүнсний материалаас сонгон үндсэн хоолыг 2 порцоор хийнэ. Технологи ажиллагаа, шинэлэг байдал, бүтээгдэхүүний зохицолдолгоог хангасан байна. Анхны боловсруулалт, дулааны боловсруулалт, таваглалт зэргийг 40 минутанд багтааж гүйцэтгэнэ. **/Технологийн картыг тухайн үед нь гараар бичих/**

3.Эмнэлэгийн хоолны тогооч- Анхны боловсруулалт, дулааны боловсруулалт, таваглалт зэргийг 45 минутанд багтааж гүйцэтгэнэ. Оролцогч нь “Цагаан хоол”- ны төрлийн хүнсний бүтээгдэхүүн болон амтлагчийг сонгон авч дараах хоол ундааг бэлтгэнэ. / Зохион байгуулагчдаас өгсөн хүнс/ Хоол олгох тавгийг өөрийн сонголтоор авч ирнэ. Хоолыг 1 порцоор бэлтгэнэ.

Үүнд: Салат- 1 порц

Шөлтэй хоол- 1 порц

Үндсэн хоол- 1 порц **/Технологийн картыг тухайн үед нь гараар бичих/**

4. Үдийн цай, Сургууль, цэцэрлэгийн хоолны тогооч- Анхны боловсруулалт, дулааны боловсруулалт, таваглалт зэргийг 45 минутанд багтаан гүйцэтгэнэ. Оролцогч “Үдийн цайны цэсийг баяжуулах” зорилгоор олон төрлийн хүнсний бүтээгдэхүүн болон амтлагчийг сонгон авч, дараах хоол, ундааг 1 төрлөөр бэлтгэнэ. Хоол олгох тавгийг өөрийн сонголтоор авч ирнэ. Бүгд хүүхдийн хоолны орц, нормоор хийгдэнэ.

Үүнд: Салат-1 порц

Шөлтэй хоол -1 порц,

Үндсэн хоол- 1 порц **/Технологийн картыг тухайн үед нь гараар бичих/**

5.Талх, нарийн боовчин. Гэрийн даалгаварт нарийн боовны үндсэн 3-4 зуурмагуудаар / Хөрөнгөтэй, тослог, давхраат, чанамал, Өндөг-цөцгийн тостой/

2.

сонгон бүтээгдэхүүн/ бага хэмжээтэй/ хийж ирэх ба урьдчилан 2 ш бялууны суурь бэлтгэж, чимэглэлийн материалуудыг өөрсдөө сонгон авч ирнэ. Нарийн боов чимэглэх материалуудыг урьчилан бэлтгэж, боловсруулаагүй байна.

Ажилбарыг 90 минутанд багтаан гүйцэтгэнэ. Хэрэглэгдэх багаж хэрэгсэл, Таваг, суурийг өөрийн сонголтоор бэлтгэж ирнэ.

6. **Брэнд хоол** – Түүхий эдийн олдоцтой, шинэлэг санаа, шинэ технологи ашигласан, орон нутгийн онцлогийг харуулсан байна. Гэрийн даалгаварт хийж, үзэсгэлэнгийн ширээнд тавина. Шилдэг хоолыг шалгаруулан батламж гардуулна.

_____оОо_____

Аймгийн Засаг даргын *2022* оны *05* дугаар
сарын *02*-ны өдрийн *133* дугаар захирамжийн
4 дүгээр хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Уралдааны төрөл	Мөнгөн дүн	Санхүүжүүлэгч байгууллага	Нийт
1	Ресторан, зоогийн газар, кафе-н тогооч /3 байр/	1- 100000 2- 80000 3- 50000 Медаль 20000	Хүнс, хөдөө аж ахуйн газар	250000
2	Гуанз, цайны газрын тогооч /3 байр/	1- 100000 2- 80000 3- 50000 Медаль 20000	Баянхонгор аймгийн Политехникийн коллеж	250000
3	Эмнэлэг, сувиллын хоолны тогооч /3 байр/	1- 100000 2- 80000 3- 50000 Медаль 20000	Эрүүл мэндийн газар	250000
4	Сургууль, цэцэрлэг үдийн цайны тогооч /3 байр/	1- 100000 2- 80000 3- 50000 Медаль 20000	Боловсрол шинжлэх ухааны газар	250000
5	Нарийн боовчин /3 байр/	1- 100000 2- 80000 3- 50000 Медаль 20000	Худалдаа аж үйлдвэрийн танхим	250000
6	Брэнд хоолны төрөл /байр/	1- 100000 2- 80000 3- 50000 Медаль 20000	Байгаль, орчин аялал жуулчлалын газар	250000
7	Өргөмжлөл /6 төрөл 18 ширхэг/	270000	Хүнс, хөдөө аж ахуйн газар	270000
8	Аннос /3*4/	230000		230000
9	Мэргэжлийн шүүгч 2 хүн /УБ-с/, Бусад зардал	1 500 000	АЗДТГ	1 500 000
Нийт зардал				3 500 000